



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 5/166

Улаанбаатар хот

Б.Түвшинжаргалыг албан тушаалаас чөлөөлөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.4, 77.7.9, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, 46.5, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан “Татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа Дундговь аймгийн татварын хэлтсийн Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч Батсүхийн Түвшинжаргал нь өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон татварын улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгон төрийн албанаас чөлөөлсүгэй.

2. Б.Түвшинжаргалын гүйцэтгэж байсан ажлыг зохих журмын дагуу хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийж дуусгахыг Дундговь аймгийн татварын хэлтэс (М.Туяацэцэг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151601498